



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансаас хөрөнгө шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Хөшөө шилжүүлэх тухай” А/69 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар дүүргийн Тамгын газрын балансад бүртгэлтэй хавсралтад заасан 360,000 /гурван зуун жаран мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий В.И.Лениний хөшөөг Улаанбаатар хотын музейн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар /Н.Энхболд/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Улаанбаатар хотын музей /С.Цацралт/-д даалгасугай.


3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар /Н.Энхболд/-т, Улаанбаатар хотын музей /С.Цацралт/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



ОДНАСАН

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2019 оны 03 сарын 01 өдрийн
 1/40 гушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас Улаанбаатар хотын музейд

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны үнэ				Хөрөнгө хүлээн авах байгууллага
						Нэгж үнэ	Нийт үнэ	Хөрөнгийн элэгдэл	Үлдэх хөрөнгө	
1	В.И.Ленины ДХ хөшөө		1954	Ш	1	400,000.00	400,000.00	39,999.96	360,000.04	Улаанбаатар хотын музей
Тавилга, эд хогшлын дүн							400,000.00	39,999.96	360,000.04	
Нийт							400,000.00	39,999.96	360,000.04	